



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 26 өдөр

Дугаар A/303

Улаанбаатар хот

Г Сургалтын ерөнхий шаардлага,
/сургалтын стандарт/, хөтөлбөр батлах
тухай

Сургалтын ерөнхий шаардлага, /сургалтын стандарт/, хөтөлбөр батлах тухай Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1, 8.4.10 дахь заалт, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 45 дугаар тогтоол, Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 02 дугаар тогтоол, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/197 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын Ерөнхий шаардлага /сургалтын стандарт/, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг 1-15 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтын Ерөнхий шаардлага /сургалтын стандарт/, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад туршилтаар хэрэгжүүлэн, нэгдсэн удирдлагаар хангаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Халиунаа/-т даалгасугай.

3. Мэргэжлийн боловсрол, сургалтын Ерөнхий шаардлага /сургалтын стандарт/, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтыг чанартай явуулах арга хэмжээ авахыг Бүсийн арга зүйн төвийн менежерүүд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирал нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД С.ЧИНЗОРИГ



800469

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын

2019 оны 09 дүгээр сарын 26. Өдрийн

1/303 дугаар тушаалын хавсралт

ТУ3894
9132155

Ерөнхий шаардлага /сургалтын стандарт/, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн жагсаалт

| № | Салбар | Мэргэжлийн нэр | МБС Ерөнхий шаардлага | ЧСС-ын хөтөлбөр | Баталж буй хавсралтын дугаар |
|-----|---------------|---|-----------------------|-----------------|------------------------------|
| 1. | Зам тээвэр | Автозам, гүүр, барилгын ажилтан /Замчин/ | √ | √ | нэгдүгээр |
| 2. | | Зам, барилгын машин механизмын оператор | √ | √ | хоёрдугаар |
| 3. | | Автомашины засварчин | √ | √ | гуравдугаар |
| 4. | | Зам, барилгын материалын лаборант | √ | √ | дөрөвдүгээр |
| 5. | Хөдөө аж ахуй | Хүлэмжийн аж ахуйн фермер | √ | √ | тавдугаар |
| 6. | | Хүнсний ногооны фермер | √ | √ | зургаадугаар |
| 7. | | Малын бага эмч | √ | √ | долоодугаар |
| 8. | | Эрчимжсэн амьтны аж ахуйн фермер /гахай/ | √ | √ | наймдугаар |
| 9. | | Ойжуулагч | √ | √ | есдүгээр |
| 10. | | Ноос, ноолуур боловсруулалтын технологийн ажилтан | √ | √ | аравдугаар |
| 11. | Барилга | Барилгын засал чимэглэлчин | √ | √ | Арван нэгдүгээр |
| 12. | | Эрчим хүчний хэмнэлттэй барилгын бүтээц угсралч | √ | √ | Арван хоёрдугаар |
| 13. | | Барилгын цахилгаанчин | √ | √ | Арван гуравдугаар |
| 14. | | Хуурай хийц угсралч | √ | √ | Арван дөрөвдүгээр |
| 15. | | Барилгын машин механизмын оператор | √ | √ | Арван тавдугаар |

---oOo---